



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/44 ДУА-2018/ЧГ/СТА-ТЦЗ Мандалговь хот

Зөрчлийг арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Боржигон Мандал өрхийн эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад санхүүгийн тайлан дахь 100,000.00 /нэг зуун мянга/ төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансын өглог, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлуулэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огох/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага цргэдтэй гуссан материалыг буюу наслжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Харилцагч байгууллагатай өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баримтжуулан барагдуулах ажлыг зохион байгуулах.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дундговь аймгийн Боржигон Мандал өрхийн эмнэлгийн дарга О.Нямсүрэн, нягтлан бодогч Г.Отгонгонгор нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:	Ж.УГТАХБАЯР
АУДИТОР	

ЗӨВШӨӨРСӨН:	О.Нямсүрэн
ДАРГА	БОРЖИГОН МАНДАЛ ЭРХИНДҮРҮЛ АЛБАН ШААРДЛАГА БЛГХН
НЯГТЛАН БОДОГЧ	Г.ОТГОНГОНГОР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гарасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж засны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.